

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/151/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/144
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Э.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд 6,711.4 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 11, 12 дугаар саруудад нийт 29,105.3 мянган төгрөгийн цалин хөлсийг анхан шатны баримт, холбогдох тооцоо бодсон баримтгүй олгосон зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх" заавартай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх", "Толилуулга", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2022 оны 107 дугаар "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол, Засгийн газрын 2022 оны 194 дүгээр "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор албан хаагчдын цалинд өөрчлөлт орж нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,800.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 6,600.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,005,406.51	155,606,788.66
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	112,805,526.66
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	112,805,526.66
3121	Төгрөг	-	112,805,526.66
31211	Төрийн сангийн харилцах		112,805,526.66
33	АВЛАГА	1,295,449.51	-
335	Бусад авлага	1,295,449.51	-
3351	Байгууллагаас авах авлага	1,295,449.51	
35	БАРАА МАТЕРИАЛ	39,709,957.00	42,801,262.00
351	Түүхий эд материал	2,424,500.00	2,190,500.00
35110	Тусгай зориулалттай материал	2,190,500.00	2,190,500.00
35130	Эм боох материал	234,000.00	
354	Хангамжийн материал	37,285,457.00	40,610,762.00
35410	Бичиг хэргийн материал	1,497,500.00	2,359,000.00
35420	Аж ахуйн материал	27,835,850.00	34,270,250.00
35460	Хүнсний материал	7,952,107.00	3,981,512.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	527,351,355.90	512,580,640.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	527,351,355.90	512,580,640.12
392	Биет хөрөнгө	523,343,355.90	508,572,640.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	538,945,763.32	538,945,763.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	(32,925,590.56)	(49,830,455.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,350,000.00	30,700,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,879,412.71)	(21,692,348.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,986,313.69	19,036,313.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,994,313.98)	(9,370,694.26)
39209	Зам, гүүрийн байгууламж	659,436.80	659,436.80
39210	Хуримтлагдсан элэгдэл	(65,943.66)	(142,877.93)
39217	Ном	267,103.00	267,103.00
393	Биет бус хөрөнгө	4,008,000.00	4,008,000.00
39301	Программ хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(100,000.00)	(100,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,008,000.00	4,008,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	568,356,762.41	668,187,428.78
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	568,356,762.41	668,187,428.78
51	Засгийн газрын хувь оролцоо	568,356,762.41	668,187,428.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	91,127,106.80	91,127,106.80
51101	Өмч: - төрийн	91,127,106.80	91,127,106.80
512	Хуримтлагдсан үр дүн	78,164,812.18	177,995,478.55
51210	Өмнөх үеийн үр дүн	(83,141,193.59)	(493,760,100.72)
51220	Тайлант үеийн үр дүн	161,306,005.77	671,755,579.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	399,064,843.43	399,064,843.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	568,356,762.41	668,187,428.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	446,613,063.00	971,197,425.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	168,177,763.00	575,384,398.32
120	Нийтлэг татварын бус орлого	164,317,763.00	575,384,398.32
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	164,317,763.00	575,384,398.32
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	164,317,763.00	575,384,398.32
122	Тусламжийн орлого	3,860,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	3,860,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	278,435,300.00	395,813,026.82
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	239,191,700.00	342,984,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	239,191,700.00	342,984,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,056,200.00	10,769,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,056,200.00	10,769,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,187,400.00	42,059,326.82
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,187,400.00	42,059,326.82
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	284,691,744.96	299,441,845.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	284,691,744.96	299,441,845.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	252,550,546.96	288,776,345.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	167,438,230.00	169,468,779.93
210101	Үндсэн цалин	119,472,019.50	135,690,691.89
210102	Нэмэгдэл	35,870,028.50	25,146,101.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,656,000.00	-
210104	Урамшуулал	7,440,182.00	8,631,986.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,815,646.86	25,339,848.74
210201	Тэтгэврийн даатгал	16,377,746.86	16,321,549.77
210202	Тэтгэмжийн даатгал	1,859,500.00	1,772,594.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,487,600.00	1,418,075.31
210204	Ажилгүйдлийн даатгал	371,900.00	347,455.14
210205	Эрүүл мэндийн даатгал	3,718,900.00	5,480,174.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,397,355.00	32,491,571.00
210301	Гэрэл, цахилгаан	2,160,267.00	2,244,195.00
210302	Түлш, халаалт	30,237,088.00	30,237,376.00
210303	Цэвэр, бохир ус	-	10,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,218,000.00	158,500.00
210401	Бичиг хэрэг	259,000.00	158,500.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,000.00	-
210404	Ном, хэвлэл	50,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	289,000.00	-
2105	Нормативт зардал	11,276,327.00	32,596,345.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.00	234,000.00
210502	Хоол, хүнс	10,765,827.00	32,123,845.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	465,500.00	238,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	890,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	890,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	474,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		474,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,904,988.10	27,357,301.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	872,450.00	4,449,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	222,000.00	654,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,810,538.10	22,252,751.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,141,198.00	10,665,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,056,200.00	10,665,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,056,200.00	10,665,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,084,998.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,084,998.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>161,921,318.04</u>	<u>671,755,579.27</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	615,312.28	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	615,312.28	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(615,312.28)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>161,306,005.76</u>	<u>671,755,579.27</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	278,435,300.00	395,813,026.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	278,435,300.00	395,813,026.82
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	239,191,700.00	342,984,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	239,191,700.00	342,984,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,056,200.00	10,769,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,056,200.00	10,769,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,187,400.00	42,059,326.82
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,187,400.00	42,059,326.82
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	278,435,300.00	280,207,500.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	278,435,300.00	280,207,500.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	246,294,102.00	269,542,000.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	167,438,230.00	164,108,379.36
210101	Үндсэн цалин	119,472,019.50	130,643,840.52
210102	Нэмэгдэл	35,870,028.50	24,730,693.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,656,000.00	-
210104	Урамшуулал	7,440,182.00	8,733,844.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,103,100.00	34,268,399.80
210201	Тэтгэврийн даатгал	17,665,200.00	23,153,999.80
210202	Тэтгэмжийн даатгал	1,859,500.00	2,718,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,487,600.00	2,414,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	371,900.00	543,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,718,900.00	5,437,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,409,355.00	32,491,571.00
210301	Гэрэл, цахилгаан	3,172,267.00	2,244,195.00
210302	Түлш, халаалт	30,237,088.00	30,237,376.00
210303	Цэвэр, бохир ус	-	10,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,040,000.00	103,500.00
210401	Бичиг хэрэг	100,000.00	103,500.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	-
210404	Ном, хэвлэл	50,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.00	-
2105	Нормативт зардал	14,860,417.00	28,153,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,000.00	
210502	Хоол, хүнс	13,315,417.00	28,153,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	890,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	890,000.00
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	-

210702	Дотоод албан томилолт	100,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	624,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		624,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,843,000.00	8,902,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,159,000.00	7,152,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	684,000.00	1,750,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,141,198.00	10,665,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,056,200.00	10,665,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,056,200.00	10,665,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,084,998.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,084,998.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>115,605,526.66</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	2,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,800,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,800,000.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		2,800,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(2,800,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	112,805,526.66
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	112,805,526.66

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	-83,141,193.59	407,050,756.64
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	-83,141,193.59	407,050,756.64
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
7	Тайлант үеийн үр дүн			161,306,005.76	161,306,005.76
8	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	78,164,812.17	568,356,762.40
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	78,164,812.17	568,356,762.40
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-571,924,912.89	-571,924,912.89
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	-493,760,100.72	-3,568,150.49
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
16	Тайлант үеийн үр дүн			671,755,579.27	671,755,579.27
17	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	91,127,106.80	399,064,843.43	177,995,478.55	668,187,428.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	386,883,900.00	272,238,500.16	114,645,399.84	70.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,883,900.00	272,238,500.16	114,645,399.84	70.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,883,900.00	272,238,500.16	114,645,399.84	70.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,782,000.00	164,108,379.36	109,673,620.64	59.94
210101	Үндсэн цалин	224,293,100.00	130,643,840.52	93,649,259.48	58.25
210102	Нэмэгдэл	45,073,600.00	24,730,693.96	20,342,906.04	54.87
210104	Урамшуулал	4,415,300.00	8,733,844.88	(4,318,544.88)	197.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,268,800.00	34,268,399.80	400.20	100.00
210201	Тэтгэврийн даатгал	23,317,500.00	23,153,999.80	163,500.20	99.30
210202	Тэтгэмжийн даатгал	2,737,800.00	2,718,600.00	19,200.00	99.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,190,300.00	2,414,900.00	(224,600.00)	110.25
210204	Ажилгүйдлийн даатгал	547,500.00	543,700.00	3,800.00	99.31
210205	Эрүүл мэндийн даатгал	5,475,700.00	5,437,200.00	38,500.00	99.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,787,400.00	32,491,571.00	295,829.00	99.10
210301	Гэрэл, цахилгаан	2,350,000.00	2,169,978.00	180,022.00	92.34
210302	Түлш, халаалт	30,237,400.00	30,311,593.00	(74,193.00)	100.25
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	10,000.00	190,000.00	5.00
2105	Нормативт зардал	31,660,800.00	28,153,250.00	3,507,550.00	88.92
210502	Хоол, хүнс	31,660,800.00	28,153,250.00	3,507,550.00	88.92
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,400,000.00	890,000.00	510,000.00	63.57
210604	Урсгал засвар	1,400,000.00	890,000.00	510,000.00	63.57
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	962,000.00	624,000.00	338,000.00	64.86
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.00	624,000.00	338,000.00	64.86
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,022,900.00	11,702,900.00	320,000.00	97.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,322,900.00	9,002,900.00	320,000.00	96.57
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,700,000.00	2,700,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	386,883,900.00	385,044,026.82	1,839,873.18	99.52
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	342,984,700.00	342,984,700.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	342,984,700.00	342,984,700.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,899,200.00	42,059,326.82	1,839,873.18	95.81
132001	Орон нутгийн төсвөөс	43,899,200.00	42,059,326.82	1,839,873.18	95.81
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	-

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	112,805,526.66	(112,805,526.66)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	15.00	15.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,769,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,769,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	103,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00
210401	Бичиг хэрэг	103,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,665,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,665,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,665,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,769,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,769,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,769,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь эрхэм зорилгоо “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх” гэж тодорхойлсон.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоол “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоол “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тогтоол “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,770.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	112,805.5	112,805.5
Авлага	1,295.4	-	(1,295.4)
Бараа материал	39,709.9	42,801.2	3,091.3
Үндсэн хөрөнгө	527,351.4	512,580.6	(14,770.8)
Нийт хөрөнгийн дүн	568,356.7	668,187.3	99,830.6
Өглөг	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	91,127.1	91,127.1	-
Хуримтлагдсан үр дүн	78,164.8	177,995.4	99,830.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	399,064.8	399,064.8	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	568,356.7	668,187.3	99,830.6

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснуудад байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 112,805.5 мянган төгрөг болж өссөн нь жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 1,295.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг тайлант онд бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,091.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан аж ахуйн материалын өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 14,770.8 мянган төгрөгийн буурсан нь тайлант хугацааны хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2,800.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, хандиваар 6,600.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 99,830.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 554,522.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 118,867.5 мянган төгрөгийн, нийт 673,389.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 4 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 386,883.9 мянган төгрөг баталснаас улсын төсвөөс 342,984.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 43,899.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 342,984.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 42,059.3 төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 280,207.5 мянган төгрөгийг зарцуулж, 112,805.5 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 272,238.5 мянган төгрөг буюу 70,4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 109,673.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 295.8 мянган төгрөг, нормативд зардал 3,507.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил,

үйлчилгээний төлбөр хураамж 338.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 320.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71801-Сургуулийн өмнөх боловсрол	386,883.9	272,238.5	114,645.4	70.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 10,769.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, бараа үйлчилгээний зардалд 103.5 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 10,665.5 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байхтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор Н.Тэмүүжин гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 342,984.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,144.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,858.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшил 109,673.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 295.8 мянган төгрөг, нормативд зардал 3,507.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 338.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 320.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 170 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 170 мэдээллээс 138 мэдээллийг хугацаандаа, 29 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5,609.3 мянган төгрөгийн 1 ажил гүйлгээ, нийт 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтаас 1 харилцагч байгууллагын 30,237.4 мянган төгрөгийн худалдан авалтыг тус тус мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллах, холбогдох албан хаагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 44,497.2 мянган төгрөгийн 8 зөрчил илэрснээс 180.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 41,846.8 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 2,470.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөн байна. Үүнээс тайлант онд 180.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 41,119.1 мянган төгрөгийн 3 албан шаардлагыг хэрэгжүүлж, 2,470.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 727.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлагыг тус тус хэрэгжүүлээгүй байна. Хэрэгжилт 75 хувьтай.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	41,846.8	3	41,119.1	60.0
Төлбөрийн акт	1	180.0	1	180.0	100.0
Зөвлөмж	2	2,470.4	2	2,470.4	100.0
Нийт дүн	8	44,497.2	6	43,769.5	75.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 60,330.8 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 1,918.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 456.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 35,816.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 22,139.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Аудитын явцад 1,918.4 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг аудитлагдсан тайлантай тулгахад эхний үлдэгдэл 1,918.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэнийг залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 456.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоов.

1. Тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 38 нэр төрлийн 456.4 мянган төгрөгийн хүнсний материал бүртгэлтэй, жилийн эцсийн тооллогын бүртгэлээр нотлогдохгүй, дутагдсан нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тасалбар болголт", "Оршин байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн тооллогоор дутагдсан бараа материалыг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар 35,816.7 мянган төгрөгийн зөрчил арилгах 2 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 9 байгууллагын 6,711.4 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх" заавартай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллах, холбогдох албан хаагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант оны 11, 12 дугаар саруудад нийт 29,105.3 мянган төгрөгийн цалин хөлсийг анхан шатны баримт, холбогдох тооцоо бодсон баримтгүй олгосон нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага

өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 7 нэр төрлийн 8,641.4 мянган төгрөгийн биет хөрөнгө, 2 нэр төрлийн 100.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгүүд бүртгэлтэй байна.

Энэ нь УСНББОУС 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх.

2. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант онд даатгуулагчаас төлөх 13,397.9 мянган төгрөгийн НДШ-ийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас гүйлгээн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

												/мянган төгрөгөөр/	
Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг аудитлагдсан тайлантай тулгахад эхний үлдэгдэл 1,918.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэнийг залруулсан.	1	1,918.4			1	1,918.4	1	1,918.4				
	Дүн	1	1,918.4			1	1,918.4	1	1,918.4				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
		Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Тайлант хугацаанд огт хөдөлгөөн ороогүй 38 нэр төрлийн 456.4 мянган төгрөгийн хүнсний материал бүртгэлтэй, жилийн эцсийн тооллогын бүртгэлээр нотлогдохгүй, дутагдсан	1	456.4	1	456.4	-	-	-	-	-	-	-	-
2	Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад 9 байгууллагын 6,711.4 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	1	6,711.4	-	-	-	-	-	-	1	6,711.4	-	-
3	Тайлант оны 11, 12 дугаар саруудад нийт 29,105.3 мянган төгрөгийн цалин хөлсийг анхан шатны баримт, холбогдох тооцоо бодсон баримтгүй олгосон	1	29,105.3	-	-	1	29,105.3	-	-	-	-	-	-
4	Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 7 нэр төрлийн 8,641.4 мянган төгрөгийн биет хөрөнгө, 2 нэр төрлийн 100.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгүүд бүртгэлтэй	1	8,741.4	-	-	-	-	1	8,741.4	-	-	-	-
5	Тайлант онд даатгуулагчаас төлөх 13,397.9 мянган төгрөгийн НДШ-ийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас гүйлгээн зарцуулсан	1	13,397.9	-	-	-	-	1	13,397.9	-	-	-	-
	Дүн	5	58,412.4	1	456.4	1	29,105.3	2	22,139.3	1	6,711.4	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансанд мэдээлбэл зохих 170 мэдээллээс 138 мэдээллийг хугацаандаа, 29 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5,609.3 мянган төгрөгийн 1 ажил гүйлгээ, нийт 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтаас 1 харилцагч байгууллагын 30,237.4 мянган төгрөгийн худалдан авалтыг тус тус мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	1	35,846.7			1	35,846.7		
	Дүн	1	35,846.7			1	35,846.7		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn